

ГАДААДЫН ИРГЭН, ХАРЬАТЫН ГАЗРЫН ДОТООД АУДИТЫН  
2024 ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН АЖЛЫН ТАЙЛАН

2024 оны 07 дугаар сарын 03

Улаанбаатар хот

Засгийн газрын 2015 оны 483 дугаар тогтоолоор баталсан “Дотоод аудитын дүрэм”, Хууль зүй, дотоод хэргийн сайдын дэргэдэх Дотоод аудитын хорооны 2017 оны 02 дугаар тогтоолоор баталсан “Дотоод аудитын журам”, Гадаадын иргэн, харьяатын газрын Дотоод аудитын 2024 оны төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу эхний хагас жилийн байдлаар дараах ажлыг хийж гүйцэтгэлээ.

Нэг.Төсөв, санхүүгийн чиглэлээр

Байгууллагын дотоод аудитын 2024 оны төлөвлөгөөний дагуу төсөв, санхүү болон үйл ажиллагааны чиглэлээр 2, Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд 2, нийцлийн аудитын чиглэлээр 1, нийт 5 удаагийн төлөвлөгөөт хяналт шалгалтыг хийж, гүйцэтгэсэн байна.

Хяналт шалгалтыг төрлөөр нь ангилвал:

№	Хяналт, шалгалтын төрөл	Хамрагдсан байгууллагын нэр	Хяналт шалгалтын тоо	Тайлбар
1	Санхүүгийн болон үйл ажиллагааны чиглэлээр аудит	Зүүн бүс дэх газар	1 удаа	Төлөвлөгөөт
2		Агаарын замын боомт хариуцсан газар	1 удаа	Төлөвлөгөөт
3	Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд	Төв болон орон нутаг дахь газар, хэлтэс	2 удаа	Төлөвлөгөөт
4	Нийцлийн аудитын чиглэлээр	Агаарын замын боомт хариуцсан газар гэрээ, тушаал, шийдвэр	1 удаа	Төлөвлөгөөт

Нэг. Санхүүгийн болон үйл ажиллагааны чиглэлээр

а) Байгууллагын даргын 2024 оны 05 дугаар сарын 01-ний өдрийн 01-02/21 дугаар удирдамжийн дагуу Зүүн бүс дэх газрын захиргаа, санхүүгийн 2024 оны нэгдүгээр улирлын үйл ажиллагаанд 05 дугаар сарын 06-10-ны өдрүүдэд гүйцэтгэлийн хяналт шалгалт хийж гүйцэтгэн, үр дүнг удирдлагад 05 дугаар сарын 15-ны өдөр 01-02/70 дугаар илтгэх хуудсаар танилцууллаа.

б) Байгууллагын даргын 2024 оны 05 дугаар сарын 17-ны өдрийн 01-02/27 дугаар удирдамжийн дагуу Агаарын замын боомт хариуцсан газрын зөрчил шалган шийдвэрлэлт, захиргаа, санхүүгийн 2023 он, 2024 оны нэгдүгээр улирлын үйл ажиллагаанд 05 дугаар сарын 20-24-ний өдрүүдэд хяналт шалгалтыг хийж гүйцэтгэн, үр дүнг удирдлагад 06 дугаар сарын 12-ны өдрийн 01-02/86 дугаар илтгэх хуудсаар танилцуулж, мөн сарын 18-ны өдөр Удирдлагын зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлэн, тус хуралдаанаас гарсан шийдвэрийн дагуу 06 дугаар сарын 19-ний өдөр 01 дугаартай “Зөрчил, дутагдлыг арилгаж, ажлын хариуцлага сайжруулах тухай” албан даалгаврыг Агаарын замын боомт хариуцсан газарт хүргүүлээ.

## Хоёр.Нийцлийн аудитын чиглэлээр

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангах зорилгоор төв болон орон нутаг дахь нэгжүүдийн цахим хуудсан дахь хуулийн хэрэгжилт болон түүнийг сайжруулах, хуулийн хугацаанд мэдээ, тайланг үнэн зөв, иж бүрэн байршуулж хэвшүүлэх талаар байгууллагын даргын 2024 оны 01-09/01, 01-09/03 дугаар удирдамжийн дагуу төв болон боомт, орон нутаг дахь нэгжүүдийн Шилэн дансны тухай хуулийн 2023 оны дөрөвдүгээр улирал, 2024 оны нэгдүгээр улирлын хэрэгжилтэд дотоод аудит хийн, 2024 оны 01 дүгээр сарын 19-ний өдөр 01-09/01, мөн оны 04 дүгээр сарын 17-ны өдөр 01-09/02 дугаар илтгэх хуудсаар удирдлагад танилцуулж, ер-мэдээллийн санд 01 дүгээр сарын 26-ны өдөр, 04 дүгээр сарын 22-ны өдөр тус тус нээлттэй байршууллаа.

Түүнчлэн 2023 оны жилийн эцсийн болон дөрөвдүгээр улирлын тайланг 2024 оны 01 дүгээр сарын 22-ны өдөр 01/173 дугаар албан бичгээр, 2024 оны нэгдүгээр улирлын хэрэгжилтийн тайланг 04 дүгээр сарын 14-ний өдөр [tumurochir@mojha.gov.mn](mailto:tumurochir@mojha.gov.mn) цахим хаягаар тус тус Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлэв.

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг ханган ажиллах талаар аудитын зөвлөмжийг 2024 оны 01 дүгээр сарын 23-ны өдөр 09/04 дугаар, мөн 04 дүгээр сарын 22-ны өдөр 09/14 дугаар дотоод албан бичгээр тус тус зохион байгуулалтын нэгжүүдэд хүргүүлэн, зөвлөмжийн биелэлтэд хяналт тавин ажиллалаа.

Төв болон орон нутаг дахь нэгжүүдийн цахим хуудаст байршуулсан 12 дугаар сарын тоон мэдээлэл, 01-05 дугаар сарын тоон мэдээлэлд сар бүрийн 06-08-ны өдрүүдэд хяналт тавин, хариуцсан албан тушаалтантай утсаар болон цахимаар холбогдон ажилласан.

Байгууллагын даргын баталсан хүчин төгөлдөр үйлчилж буй захиргааны хэм хэмжээний актад Захиргааны ерөнхий хуулийн 69 дүгээр зүйлийн 69.1 дэх хэсэгт заасны дагуу хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, үр дүнгийн тайланг 2024 оны 04 дүгээр сарын 18-ны өдөр 01/795 дугаар албан бичгээр Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлсэн.

Гурав. Бусад асуудлаар

Байгууллагын дотоод аудитын чиглэлээр 2023 оны гүйцэтгэсэн ажлын тайлан, 2024 оны дотоод аудитын төлөвлөгөөний төслийг 2023 оны 12 дугаар сарын 08-ны өдрийн 01/2140 дугаар албан бичгээр, Үндэсний аудитын газрын 2022 оны акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилтийг 2023 оны 12 дугаар сарын 14-ний өдрийн 02/2197 дугаар албан бичгээр Хууль зүй, дотоод хэргийн яаманд, мөн Үндэсний аудитын газраас 2023 оны санхүүгийн тайланд аудит хийж, өгсөн зөвлөмж, акт албан шаардлагын тоо, судалгаа, мэдээллийг [tumurochir@mojha.gov.mn](mailto:tumurochir@mojha.gov.mn) хаягаар 2024 оны 05 дугаар сарын 17-ны өдөр тус тус хүргүүлсэн.

Үндэсний аудитын газрын 2022 оны акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилтийг 2024 оны 02 дугаар сарын 13-ны өдөр, 2023 оны акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилтийг 2024 оны 06 дугаар сарын 06-ны өдөр [Fas.audit.mn](http://Fas.audit.mn) цахим системд тус тус баталгаажуулав.

Байгууллагын 2024 оны эрсдэлийг сааруулах үйл ажиллагаа буюу хариу арга хэмжээний төлөвлөгөөг 2023 оны 12 дугаар сарын 19-ний өдөр байгууллагын даргаар батлуулж, мөн оны 12 дугаар сарын 25-ны өдөр 09/2274 дугаар албан бичгээр Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлсэн.

Зохион байгуулалтын нэгжүүдэд эрсдэлийг сааруулах үйл ажиллагаа буюу хариу арга хэмжээний төлөвлөгөөний эхний хагас жилийн биелэлтийг гарган ирүүлэхийг 2024 оны 05 дугаар сарын 28-ны өдрийн 08/22 дугаар дотоод албан бичгээр хүргүүлэн, хяналт тавин ажиллаж байна.

Байгууллагын 2023 он, 2024 оны нэгдүгээр улиралд иргэн, албан хаагчаас ирүүлсэн өргөдөл, гомдлын агуулга болон шийдвэрлэлт, байгууллагаас иргэдэд үзүүлж буй үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах чиглэлээр 8 зорилтын хүрээнд, байгууллагын дотоод үйл ажиллагааг сайжруулах чиглэлээр хүний нөөцийн бодлого, хөтөлбөр албан хаагчдад нийцэж буй эсэхэд дүн шинжилгээ хийж, тус тус судалгаа, шинжилгээний нэгдсэн тайлан гаргаж удирдлагад танилцууллаа.

Байгууллагын даргын 2023 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн А/472 дугаар тушаалын дагуу байгууллагын хэмжээнд мөрдөгдөж буй мэдээллийн технологийн үйл ажиллагаатай холбоотой салбарын сайдын болон байгууллагын даргын тушаалаар баталсан эрх зүйн актуудыг шинэчлэн боловсруулах чиг үүрэг бүхий ажлын хэсэгт, мөн 2024 оны 01 дүгээр сарын 05-ны өдрийн А/05 дугаар тушаалын дагуу байгууллагын чиг үүрэгт хамаарах асуудлаар Засгийн газрын тогтоол, Хууль зүй, дотоод хэргийн сайдын болон байгууллагын даргын тушаалаар баталсан нийтээр дагаж мөрдөх эрх зүйн актуудад дүн шинжилгээ хийж, холбогдох хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төсөл боловсруулах ажлын хэсэгт нийцлийн аудит хариуцсан ахлах мэргэжилтэн;

Өмч хамгаалах Байнгын зөвлөлийн 2023 оны 12 дугаар сарын 04-ний өдрийн төв, орон нутаг дахь нэгжүүдийн 2023 онд элэгдлийн хугацаа дууссан үндсэн хөрөнгийн талаар хэлэлцсэн хуралдаан, баримт бичиг нягтлан шалгах комиссын 2023 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн хуралдаанд, байгууллагын даргын 2024 оны 02 дугаар сарын 07-ны өдрийн А/54 дугаар тушаалаар албан тушаалын тодорхойлолтыг шинэчлэн боловсруулах ажлын хэсэгт дотоод аудит хариуцсан ахлах мэргэжилтэн;

Байгууллагын даргын 2023 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн А/467 дугаар “Эд хөрөнгийн тооллого зохион байгуулах тухай” тушаалын дагуу 12 дугаар сарын 15-25-ны өдрүүдэд ажлын хэсэгт аудитын мэргэжилтэн;

Байгууллагын даргын 2023 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн А/500 дугаар тушаалаар байгуулсан “Тээвэр шатахуун бэлтгэн нийлүүлэх” ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хорооны 2024 оны 04 дүгээр сарын 16-ны өдрийн хуралд хяналт-шинжилгээ хариуцсан ахлах мэргэжилтэн;

Хууль зүй, дотоод хэргийн яаманд зохион байгуулагдсан Захиргааны хэм хэмжээний акт ба хүний эрх сэдэвт хэлэлцүүлэгт 2024 оны 04 дүгээр сарын 24-ний өдөр нийцлийн аудит хариуцсан ахлах мэргэжилтэн нар тус тус ажиллав.